



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 15/26

Ховд

Ш.Батжаргалыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших болсонтой холбогдуулан өөрийн хүсэлтийг үндэслэн Ширэндэвийн Батжаргалыг “Шинэ Ховд” баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-ын даргын албан тушаалаас 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.


2. Ш.Батжаргалын ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, байгууллагын 2023, 2024 оны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар байгуулсугай.

3. Ш.Батжаргалын ажлыг хүлээлцэж, холбогдох тооцоог хийж дуусгахыг “Шинэ Ховд” баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч (Н.Өлзийхишиг), байгууллагын 2023, 2024 оны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулсан талаарх тайлан мэдээллийг 7 хоногийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (П.Мягмартүвшин) нарт тус тус даалгасугай.

4. “Шинэ Ховд” баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-ын даргын албан тушаалд тус газрын харьяа “Шинэ Ховд” үйлдвэрлэл технологийн паркийн дарга Б.Наранбаатарыг томилсугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Х.БАТБОЛД



8400001 1514

Zah-B/26 Ba


Засаг даргын 2024 оны  
07 дугаар сарын 30-ны өдрийн  
Б/26 дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт



## АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Эрдэнэбат (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- Гишүүд:
- Б.Түмэнжаргал (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)
  - С.Мөнх-Очир (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)
  - Н.Өлзийхишиг ("Шинэ Ховд" баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч)
- Нарийн бичгийн дарга: Т.Буянзаяа (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

-оОо-



Засаг даргын 2024 оны  
07 дугаар сарын 30-ны өдрийн  
Б/26 дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт

**БАЙГУУЛЛАГЫН 2023, 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: П.Мягмартүвшин (Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч)

Гишүүд: У.Гандэмбэрэл (Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: Т.Аззаяа (Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дотоод аудитор)

-оОо-